

Монгол–Солонгосын харилцаан дахь буддын шашны түүхэн нөлөө

Мишиг-Ишийн Батаа, доктор (Ph.D)

Шинжлэх Ухааны Академи, Философийн хүрээлэн

Улаанбаатар, Монгол Улс,

Холбоо барих зохиолч: bataa_m@mas.ac.mn,

<https://orcid.org/0000-0002-9608-4645>

Дүйнхаржавийн Дэмбэрэл, доктор (Ph.D)

Шинжлэх Ухааны Академи, Философийн хүрээлэн

Улаанбаатар, Монгол Улс, demberel_d@mas.ac.mn,

<https://orcid.org/0009-0002-1431-3481>

Article history

Received : 2025-08-31

Accepted : 2025-11-30

Published : 2025-12-31

Түлхүүр үгс

Монгол, Солонгос, Бурханы шашин, Юань улс, Курё, Сажа урсгал, соёлын харилцаа

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Монгол болон Солонгос оронд Бурханы шашин хэрхэн дэлгэрч, тухайн улс орнуудын нийгэм, төрийн бодлого, соёлын өвд үзүүлсэн нөлөөг түүхэн үечлэл, шашны урсгалын хөгжил болон соёлын огтлолцлын хүрээнд харьцуулан судлав. Монгол Улсад Буддын шашин гурван том үе шатаар дамжин хөгжсөн ба Хүннүгийн үеэс эхлэн нэвтэрч, XIII-XIV зуунд Сажав урсгалаар дамжин төрийн бодлого болж, улмаар XVI зуунаас хойш Гэлүтба урсгал өргөн дэлгэрсэн.

Солонгосын хойгт Бурханы шашин нь IV зуунаас эхлэн нэвтэрч, Махаяна (Их хөлгөн) уламжлалын дагуу хөгжсөн бөгөөд XIII-XIV зууны үед Юань улс болон Корё улсын харилцаагаар дамжин Төвөдийн Сажав урсгалын нөлөө орж ирсэн нь хоёр орны шашин, соёлын уялдааны тод илрэл болсон.

Судалгаанд түүхэн баримт, археологийн эх сурвалж, шашны урсгалуудын үзэл санаа, соёлын биет өвийг харьцуулан авч үзсэн бөгөөд Монгол, Солонгосын Бурханы шашин нь хөгжлийн хувьд тусдаа замналтай боловч түүхэн цаг үеийн огтлолцол, харилцан нөлөөлөл нь хоёр орны соёлын харилцаанд чухал үүрэг гүйцэтгэсэн болохыг баталж байна. Энэ нь өнөөгийн шашин, соёлын харилцааны судалгаанд чухал эх

сурвалж болон үйлчилж байгаа бөгөөд цаашдын харьцуулсан судалгаанд шинэлэг хандлага, ойлголт өгөх ач холбогдолтой юм.

The historical influence of buddhism on Mongolian-Korean relations

Mishig-Ish Bataa (Ph.D)

*Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences
Ulaanbaatar, Mongolia,*

Corresponding author: bataa_m@mas.ac.mn,

<https://orcid.org/0000-0002-9608-4645>

Duinkharjav Demberel (Ph.D)

*Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences
Ulaanbaatar, Mongolia, demberel_d@mas.ac.mn,*

<https://orcid.org/0009-0002-1431-3481>

Keywords

*Mongolia, Korea, Buddhism,
Yuan dynasty, Goryeo, Sakya
school, cultural exchange*

© The Author(s), 2025



Abstract: This article explores the historical development and diffusion of Buddhism in Mongolia and Korea, emphasizing the distinctive trajectories and mutual influences between the two regions. In Mongolia, Buddhism evolved through three major historical phases: from its initial presence during the Xiongnu period, through the adoption of Tibetan Sakya and Kagyu traditions under the Mongol Empire in the 13th century, to the widespread institutionalization of the Gelug school from the late 16th century onward. In Korea, Buddhism was introduced in the 4th century and grew predominantly under the Mahāyāna tradition, particularly during the Three Kingdoms and Unified Silla periods. During the 13th–14th centuries, religious and political ties between the Yuan dynasty and the Goryeo kingdom facilitated the introduction of the Tibetan Sakya school into Korea, which left a lasting mark on Korean Buddhist art, philosophy, and ritual practice.

Drawing upon historical texts, archaeological evidence, and doctrinal analysis, the study highlights how, despite following different historical paths, Mongolian and Korean Buddhism intersected at crucial moments in history. These intersections contributed significantly to the cultural, religious, and artistic developments in Northeast Asia and remain valuable areas for contemporary comparative religious studies. The article further underscores the importance of Buddhist exchange as a foundation for understanding the broader scope of Mongol–Korean relations throughout history.

I. ОРШИЛ

Бурханы шашин нь НТӨ VI зуунд Энэтхэгт үүссэн цагаасаа хойш Ази тивийн улс орнуудын гүн ухаан, соёл, нийгмийн хөгжлийн чухал бүрэлдэхүүн хэсэг болон төлөвшсөн билээ. “Миний сургаал умраас умарт дэлгэрнэ” хэмээх бошгийг бэлгэдэн, энэхүү шашны сургаал нь Төв Азийн

уудам нутаг, Зүүн хойд Азийн олон улс оронд түгэн дэлгэрч, тухайн бүс нутгийн түүх, соёлын онцлогт зохицон, олон урсгал, уламжлалаар хөгжиж ирсэн нь судалгааны онцгой чиглэл болсоор байна.

Бурханы шашныг уламжлалт ангиллаар нь авч үзвэл гурван үндсэн урсгал буюу

Тхеравада (Бага хөлгөн), Махаяана (Их хөлгөн), Важраяана (Очирт хөлгөн буюу тарнийн ёс) гэсэн салбаруудын хэлбэрээр өргөжин тэлсэн байдаг. Эдгээр урсгалууд нь онол сургаал, зан үйл, бясалгалын аргын хувьд өөр өөр чиг хандлагатай бөгөөд тухайн орон нутгийн нийгэм, соёлын тогтолцоонд нийцэн хөгжжээ.

Монгол Улсад Бурханы шашин эртний Хүннү гүрний үеэс нэвтэрч, улмаар XIII зууны Монголын Их эзэнт гүрний үед төрийн шашин болон төлөвшсөн түүхэн замналтай. Энэхүү түүхэн үйл явц нь Төвөдийн шашны урсгалуудтай, тэр дундаа Сажа, Гаржүд, Нима, Гэлүг зэрэг уламжлалтай нягт уялдаатайгаар өрнөсөн нь тухайн үеийн олон улсын шашин-соёлын харилцааны нэгэн тод жишээ болж байна.

Нөгөө талаас, Солонгосын хойгт Бурханы шашин НТ IV зууны үеэс Кугурё, Пэгжэ, Шилла зэрэг вант улсуудын төрийн бодлого, Хятадын нөлөөний хүрээнд нэвтэрч, Махаяана урсгалын дагуу хөгжсөн бөгөөд VIII–XIV зууны хооронд өөрийн гэсэн философи, зан үйлийн онцлогтой уламжлалыг бүрдүүлжээ. Ялангуяа XIII–XIV зууны үед Юань гүрэн болон Корё улсын хоорондын улс төр, шашны харилцаанд Төвөдийн Сажава урсгалын нөлөө Солонгост нэвтэрсэн нь хоёр орны бурхны шашны харилцан үйлчлэлийн чухал үеийг төлөөлдөг.

Иймд энэхүү өгүүлэл нь Монгол, Солонгосын Бурханы шашны үүсэл, хөгжлийн үе шат, онцлог шинж, харилцан нөлөөллийг түүхэн цаг хугацаа болон соёлын солилцооны үүднээс судалж, Зүүн хойд Азийн буддын шашны судлалын хүрээнд хоёр орны харилцааны байр суурийг шинжлэх зорилготой юм.

II. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү судалгаанд Монгол болон Солонгосын бурхны шашны үүсэл, хөгжлийн явц, харилцан

үйлчлэлийн түүхэн нөхцөл, соёлын огтлолцлыг шинжлэхэд дараах онолын болон практик арга зүйг ашигласан болно.

Юуны өмнө, **түүхэн шинжилгээний арга** (historical analysis method)-аар дамжуулан хоёр улсын шашны харилцааг тодорхой түүхэн үед авч үзэж, эх сурвалж бичгүүд, архивын баримт, эрдэмтдийн судалгааны бүтээлүүдэд тулгуурлан түүхэн үйл явдлуудыг цэгцтэйгээр тайлбарласан. Үүнд Монголын Зава Дамдин ламын *Алтан дэвтэр буюу Монголын Бурханы шашны түүх*”, “*Юань улсын түүх буюу Юань ши(元史)*”, Солонгосын “*Самгүг саги(三國史記) буюу Гурван улсын түүхийн тэмдэглэл*”, “*Курёса(高麗史) буюу Курё улсын түүх*” зэрэг эх сурвалжийг ашигласан бөгөөд тухайн эх сурвалжуудын найдвартай байдлыг шүүн тунгаах, харьцуулан тайлбарлахад анхаарсан.

Хоёрдугаарт, **логик шинжилгээний арга** (logical analysis method)-аар дамжуулан шашны үзэл суртал, урсгалын ялгаа болон хөгжлийн зүй тогтол, уялдаа холбоог задлан шинжилсэн. Энэхүү арга нь Бурханы шашны дотоод гүн ухааны элементүүд, урсгалуудын онцлог, зан үйлийн ялгаа зэргийг тайлбарлахад чухал үүрэгтэй байсан.

Гуравдугаарт, **харьцуулсан судалгааны арга** (comparative method)-аар Монгол болон Солонгос дахь Бурханы шашны хөгжлийн түүхэн үе шат, шашны урсгалуудын нөлөө, төр-шашны харилцааны хэлбэр зэргийг харьцуулан авч үзсэн. Энэ нь хоёр орны шашны хөгжилд нөлөөлсөн гадаад болон дотоод хүчин зүйлсийг тодорхойлоход ач холбогдолтой байсан бөгөөд харилцан адилгүй шинжүүдийн зэрэгцээ уялдаа холбоо, нөлөөллийн чиглэлүүдийг илрүүлж өгсөн.

Мөн танин мэдэхүйн буюу гносеологийн арга (*epistemological approach*)-аар шашны үзэл санаа, сургаал, гүн ухааны элементүүдийг зөв ойлгож, тайлбарлахыг зорьсон. Энэ нь шашны философийн агуулгыг судалгаанд зөв байршуулж, зөвхөн түүхэн үйл явдал төдийгүй шашны үзэл суртлын төвлөрөлд ч анхаарах боломжоор хангаж өгсөн.

Эцэст нь, **интердисциплинар буюу салбар хоорондын хандлагаар** түүх, шашин судлал, соёл судлалын мэдлэгийг уялдуулан ашигласан бөгөөд энэ нь судалгааны өргөн хүрээ, холимог шинжийг хангаж, илүү иж бүрэн дүгнэлт хийх боломжийг бүрдүүлсэн.

III. СУДАЛГААНЫ ҮР ДҮН, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ:

Монгол дахь Бурханы шашны дэлгэрэлт Монгол нутгийн өндөр уулс, уудам тал нутгийн газар нутагт Бурханы шашин эртний үеэс уламжлагдан ирсэн бөгөөд энэхүү түүхийг гурван том үе шатанд хувааж үздэг.

Үүнд:

1. Анхны дэлгэрэлт (МЭӨ I зуун – XII зуун)

Монголд Бурханы шашин анхлан дэлгэрсэн тухай мэдээ нь Хүннүгийн үеэс улбаатай бөгөөд Ли улсаар дамжин орж ирсэн тухай Зава Дамдины “Алтан дэвтэр”-т тэмдэглэгдсэн байдаг (Zava Damdin, 1933). Археологийн олдворуудын дотор суварга, чулуун хөшөө, бурханы шүтээн зэрэг нь Монголын язгууртнуудын дунд шашин дэлгэрч байсныг гэрчилдэг (Д.Цэрэнсодном, Монголын Бурханы шашны уран зохиол, 1997). Энэ үеийн дэлгэрэлт нь голчлон худалдаа, соёлын солилцоогоор дамжин явсан гэж үздэг.

2. Хоёр дахь дэлгэрэлт (XII зууны сүүл – XIV зууны дунд үе)

XII зууны сүүл үеэс XIV зууны дунд хүртэл Чингис хаан болон түүний залгамжлагч Өгэдэй, Гүюг, Мөнх хаадын үед бурхны шашны лам нар болон хийд сүмүүдийг албан татвараас чөлөөлөх зэрэг дэмжлэг үзүүлж байв (William of Rubruck, *Itinerarium*, 1255; *Юань ши* (元史), 1370; Plano Carpini, *Historia Mongalorum*, 1220–1240). Бурханы шашны лам нар заримдаа ордны ёслолд оролцдог байсан зэргээс үзэхэд бурхны шашин хааны **ордон, сурвалжит ихэс дээдсийн түвшинд л оршиж байсан** боловч нийт ард түмэнд дэлгэрч чадаагүй гэж үздэг.

Мөн Мөнх хааны үе буюу 1254 онд Их Монгол улсын нийслэл Хархорум хотод шашны мэтгэлцээн болсон. Үүнд Христийн шашин, Буддын шашин, Исламын шашны төлөөлөгчид оролцсон түүхэн баримт бий. (William of Rubruck, *Itinerarium*, 1255) Энэхүү Хархорумд болсон олон шашны мэтгэлцээн нь дэлхийд хамгийн анхны шашны уулзалт хэмээн хүлээн зөвшөөрддөг бөгөөд их гүрний шашны хүлээн зөвшөөрөх, тэнцвэртэй байдлыг хангах төрийн бодлогын нэгэн том жишээ болох юм.

XIII зууны дунд үеэс Хубилай хааны үед бурхны шашныг **төрийн шашин болгож албан ёсоор институцийн түвшинд хүлээн зөвшөөрөх болсон**. Хубилай хаан Төвөдийн Сажава урсгал, Гаржүдва урсгалын лам нарыг Монголд урьж бурхны шашныг төрийн бодлогод нэвтрүүлэн улс даяар дэлгэрүүлсэн. Сажа лам Пагва Лодойжанцанг (Gromgon Chosrgyal 'Phagspa, 1235–1280)-ыг “Улсын багш” хэмээн өргөмжилснөөр Монголын төр-шашны харилцааг институцийн түвшинд баталгаажуулсан нь түүхэн ач холбогдолтой (Zava Damdin, 1933). Энэ нь Хубилай хааны үед **төр шашны албан ёсны бүтэцийг** тод харуулах бөгөөд Монголын эзэнт гүрний төр-шашны харилцааны түүхэнд чухал үе шатыг тэмдэглэж байна.

3. Гурав дахь дэлгэрэлт (XIV зууны сүүл – XX зууны эхэн) Монголд бурхны шашны гурав дахь дэлгэрэлт нь XV-XVI зууны үеэс эхлэн XX зууны эхэн үеийг хамарсан бөгөөд энэ үе нь шашны сургууль, сүм хийдийн тогтолцоо, шашны боловсрол, соёл урлаг, гүн ухаан, төр-шашны харилцаа зэргээрээ онцлогтой.

Төвөдийн **Богд Зонхова (1357–1419)**-гийн үндэслэсэн **Гэлүгбийн** ёс Монголд энэ үед хүчтэй дэлгэрч, тухайн үеийн нийгмийн бүхий л хүрээнд нөлөө үзүүлсэн.

Энэ гурав дахь дэлгэрэлтийн үед хамгийн эхэнд онцлох хүмүүс бол Түмэдийн **Алтан хаан (1507–1582)** болон Халхын **Автай сайн хаан (1554–1588)** нар юм. Алтан хаан 1578 онд Төвөдийн лам **Содномжамцыг (Sonam Gyatso, 1543–1588)** Монголд залж, түүнийг “Очир дара Далай лам” хэмээн өргөмжилсөн нь Төвөд–Монголын шашин, улс төрийн харилцаанд шинэ эрин үеийг эхлүүлсэн түүхэн үйл явдал болсон (Petch, 1950). Үүнээс хойш “далай лам” гэдэг нэрийг уламжлан явдаг. Энэ үед **Содномжамц лам** Монголчуудад зориулан Бодь мөрийг зэргийн хөтөлбөр “Тунгаамал алт” хэмээх шаштирыг айлдсан. Мөн Халхын Автай сайн хан 1586 онд Эрдэнэ Зуу хийдийг байгуулсан зэрэг түүхэн үйл явдал болжээ.

XVII зууны дунд үеэс Анхдугаар Богд **Өндөр гэгээн Занабазар (1635–1723)** Монголын соёл, урлаг, гүн ухаан, хэл бичиг, уран баримал, уран зураг зэрэг олон салбарт үнэлэшгүй хувь нэмэр оруулсан юм. Тэрбээр зөвхөн шашны зүтгэлтэн байгаад зогсохгүй түүний урласан бурхан шүтээнүүд, ялангуяа Очирдарь, Майдар, хорин нэгэн **Дарь Эх**, Цагаан дарь эх, **Аюуш** зэрэг нь Монголын урлагийн оргил бүтээлүүдийн нэг хэмээн үнэлэгддэг. Мөн түүний зохиосон **Соёмбо бичиг**,

Тод бичиг зэрэг нь Монголын шашин соёлын өвд үлэмж баялаг нэмэр болсон. Тухайн үеэс хойш Монголд олон зуун сүм хийд, дацан сургуулиуд байгуулагдаж, лам нарын боловсролын тогтолцоо эрчимтэй хөгжсөн.

Бурханы шашны гүн ухааны, тарнийн ёсны, тэжээхүйн ухааны, зурхайн зэрэг чиглэлээр мэргэшсэн бүтэцтэй болж, Энэтхэгийн Наландрын их сургуулийн гүн ухааны уламжлалыг үндэс болгосон. Зөвхөн оюун санааны төдийгүй, Монголын ард иргэдийн **аж амьдралын хэв маяг, ёс заншил, хувцас хэрэглэл** зэрэг олон салбарт гүн гүнзгий нөлөө үзүүлсэн. Гэлүгбийн урсгал нь Энэтхэгийн Наландрын их сургуулийн уламжлалыг залгамжилж, хожмын Төвөдийн бурхны шашны гол урсгал болон төлөвшсөн билээ. Бурханы шашны сургаал нь энэрэл нигүүлсэхүйн үзэл, олон нийтэд ёс суртахууны боловсрол олгох гол үүрэг гүйцэтгэж байлаа. Энэ үеийн түүхэн хүмүүсийн төлөөлөл болсон Өндөр гэгээн Занабазарын дагаж номын “хүрээ” үүсэж, олон дахин нүүдэллэсэн бөгөөд 7 дахь нүүдэл одоогийн Монгол улсын нийслэл Улаанбаатар хот болох суурийг тавьсан байдаг.

Солонгос дахь Бурханы шашны дэлгэрэлт

Солонгосын хойгт бурхны шашин эртний үеэс эхлэн түгсэн бөгөөд тухайн үеийн улс төр, хөрш зэргэлдээ орнуудын шашны нөлөөлөлтэй салшгүй холбоотойгоор хөгжжээ. Судлаачид Солонгосын бурхны шашны хөгжлийг үндсэн гурван үеэр хуваадаг:

1. Эхэн үе (IV–X зуун) МЭ 372 онд Кугурё улсад 17 дугаар хаан Су сү римийн үед Өмнөд Цинь улсаас Сүндү хэмээх лам элч нарын хамтаар ирж, бурхны шашны холбогдолтой эд зүйлс бэлэглэсэн. 374 онд Аду лам ирж, Су сү рим хаан Чугунса болон И пулланса

хийдийг байгуулж, лам нарыг суурьшихыг зөвшөөрсөн гэж Самгүг саги (三國史記) буюу Гурван улсын түүхийн тэмдэглэл хэмээх Солонгосын эх сурвалжид тэмдэглэгдэн үлджээ. 384 онд Пэгжэ улсад, 527 онд Шилла улсад тус тус Бурханы шашин орж, төрийн ивээл дор хөгжсөн.

Нэгдсэн Шилла улс (НТӨ 57–НТ 991) Бурханы шашныг албан ёсны төрийн шашин болгож, VII зуунд Вонюу (元曉, 617–686), Исан (義湘, 625–702) зэрэг нэрт эрдэмтэн мэргэд олноор төрөн гарсан. Энэ үед Хятадаар дамжин Их хөлгөний урсгал голлон дэлгэрч, Солонгосын лам нар Хятад дахь номын газруудад суралцаж, бурхны шашны системтэй мэдлэг олж авч байжээ.

2. Дунд үе (XII–XIV зуун)

XIII зуунд Корё (X–XIV) улсын сүүл хэсэгт Монголын эзэнт гүрэнтэй төр, шашны харилцаатай байсан бөгөөд энэ үед Монголчууд Төвөд рүү явж Наландрын их сургуулийн уламжлалыг дагадаг дацан сургалтаар системтэй суралцдаг шиг Солонгосчууд ч Хятадад сурч, бурхны сургаалыг судалжээ. Солонгосын бурхны шашин эхэндээ Хятадын бурхны шашнаас их зүйл авсан боловч бүхэлд нь даган дуурайх бус, зарим үед нөлөө авч, бие даасан философи ба практикийн онцлогтой болсон (Buswell & Lee, 2000). Солонгосын бурхны шашны гол чухал онцлог нь Вонюу (元曉, 617–686) ламын үүсгэсэн Нэгдмэл бурхны шашин (통불교) гэсэн ойлголт байдаг. Энэхүү нэгдмэл бурхны шашин гэдэг нь сургалт (교, 敎) ба самади бясалгалын практик (선, 禪)-ыг хооронд нь уялдуулсан бүхэл цогц сургалт болгохыг эрмэлздэг юм (Shin, 2014).

Мөн Төвөдийн Сажава урсгалын Пагва лам Монголын эзэнт гүрэнд “улсын багш” болсоны дараахан илгээсэн (Солонгосын Өмнөд Чоло аймгийн Сүнчон дахь Сүнкуанса хийдийн музейд

хадгалагддаг) захидлаар дамжуулан шашны тэргүүнд харилцаа тогтоосон. Хубилай хаан Пагва ламыг “улсын багш” цолоор өргөмжилж, шашны хэрэг эрхлэхийг даатгасан нь Солонгос дахь Монголын бурхны шашны нөлөөг гэрчилдэг.

Энэ үеийн Солонгосын Бурханы шашин нь Хятадын Чиан (禪佛教, Зен) урсгалаас эхлэлтэй ч Төвөдийн бурхны шашин дахь тарнийн ёсны нөлөө Монголоор дамжин ирсэн байна. Үүнд зарим нэгэн жишээ баримтаас дурдвал:

- Ёнбугса хийдийн хонх
- Жан-анса хийдийн хонх
- Кэсон Кёнчонса хийдийн 10 давх ар чулуун суварга
- Гёнжу дахь Магугса хийдийн суварга
- Чезү арлын Бөбхваса хийдийн Бурханы дүр зэрэг болно.

Эдгээр баримт нь Монгол, Төвөдийн бурхны шашны нөлөө Солонгост хэрхэн нөлөөлсөн болохыг харуулдаг. Их хөлгөний шашинд судрын ёс, тарний ёс гэж хоёр зүйл бий. энд дурдаж буй тарний ёсны номлол машид бага байсан нь Монголын төрийн шашин болгосон Төвөдийн бурхны шашны нөлөөгөөр зарим нэгэн өөрчлөлт гарчээ гэж үзэх болохоор байгаа юм. Дээр дурдсанчлан энэ үе нь бурхны шашнаар дамжуулан Зүүн хойд Азийн олон улсын харилцаанд онцгой байр суурь эзэлдэг. Корё улсын сүүл үе буюу XIII зуунд Монголын эзэнт гүрэнтэй төр, шашны харилцаа өрнөж байсан боловч энэ нь Монгол оронд одоогийн Гэлүгбийн ёс дэлгэрэхээс өмнөх үе байв.

3. Хожуу үе (Чусон улс, 1392–1910)

Чусон улсын (1392–1910) төрийн бодлого нь үндсэндээ Күнзийн сургаалд тулгуурлаж байсан учир бурхны шашныг албан ёсоор хүлээн зөвшөөрдөггүй байв. Үүний улмаас лам нарыг нийслэл Сөүлд нэвтрүүлэхийг

хориглож, төрийн ёслол, албан шашны харилцаанд оролцуулахгүй байх бодлогыг чанд сахисан юм (Buswell & Lee, 2000). Энэ нь буддын шашны институцийн байр суурийг сулруулж, улс төрийн хувьд нөлөө багасахад хүргэсэн. Гэвч ийм хязгаарлалт нь Бурханы шашныг бүрмөсөн доройтуулаагүй. Харин ч эсрэгээрээ, олон зуун солонгос лам нар бурхны номд тайлбар сэлт бичиж, янз бүрийн урсгалын онол, практикийг хөгжүүлсээр байсан (Kim, 2018). Сүм хийдүүд нийслэлээс алс хол, аглаг ууланд төвлөрч, бие даасан шашны төв болон өргөжин хөгжсөн нь ард олны хувийн сүсэг бишрэлийг хадгалахад чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд ард түмний дунд амьдрах, сүм хийдэд төвлөрөн уламжлалаа хадгалах нөхцөлийг бий болгосон. Энэ нь Солонгосын буддизмын үзэл санаа, сургаал дараагийн үед уламжлагдаж, XIX–XX зуунд шинэчлэл, дахин сэргэлт өрнөх суурь болсон гэж үзэж болно (Buswell, 1991; Kim, 2018). Чусон улсын үед Монголын бурхны шашны албан ёсны харилцаа эрс хумигдсан. Гэсэн хэдий ч бурхан шашны сургаал, үзэл санаа албан ёсны харилцаанаас гадуур зарим хийд, хувийн сүсэгтэн олны дунд дамжин үлдэж, Монгол, Солонгосын сэтгэхүйд тодорхой ул мөрөө үлдээжээ.

IV. ДҮГНЭЛТ

Монгол, Солонгос хоёр улс бурхны шашныг өөр өөрийн онцлогтой, газар нутгийн болон соёлын онцлогт тохируулан хүлээн авч хөгжүүлсэн. Монголд бурхны шашин Хүннүгийн үеэс эхлэн орж, XIII–XIV зуунд Юань улстай холбоотой төр-шашны харилцаа, Төвөдийн Сажаба, Гаржудба, Нимаба, Гэлүмба урсгалын лам нарын нөлөөгөөр улс даяар тархсан бол, Солонгосын хойгт Бурханы шашин IV зуунд Кугурё, Пэгжэ, Шилла улсад нэвтэрч, төрийн ивээл дор хөгжиж, XIII–XIV зуунд Монголын эзэнт гүрний нөлөөгөөр Төвөдийн

тарнийн ёсны уламжлалын зарим элементүүдийг авчирсан нь соёл, шашны харилцааны огтлолцлыг бий болгожээ.

Эдгээр харилцаа нь зөвхөн шашны түүхэнд төдийгүй, улс төр, соёл, урлагийн хөгжилд чухал нөлөө үзүүлсэн бөгөөд хоёр орны хийд, сургалтын төвүүд, архитектур, бурхны дүр, суварга зэрэг биет өвд илэрч буй нь тухайн үеийн гүн гүнзгий нөлөөг гэрчилдэг. Жишээ нь: Ёнбугса хийдийн хонх (1346), Жан-анса хийдийн хонх, Кэсон Кёнчонса хийдийн 10 давхар чулуун суварга, Гёнжу дахь Магугса хийдийн суварга, Чежү арлын Бөбхваса хийдийн бурхны дүр зэрэг нь Монгол, Төвөдийн шашны нөлөөг Солонгост харуулсан тод жишээ юм.

Чусон улсын үед төрийн бодлого нь Күнзийн сургаалд тулгуурлаж байсан ч, Бурханы шашны үзэл санаа, сургаал нь сүсэгтэн олны дунд дамжин үлдэж, дараагийн үеийн шашны хөгжилд суурь болсон юм. Харин Монголд Гэлүгбийн урсгал өргөн дэлгэрч, боловсрол, соёлын тогтолцоо бүрэлдсэн нь тухайн бүс нутгийн шашны гүн ухаан, нийгэм, соёлын бүтцэд хүчтэй нөлөө үзүүлсэн.

Эдгээр түүхэн үйл явдлууд нь Монгол, Солонгосын бурхны шашны харилцаа нь зөвхөн шашны салшгүй хөгжлийг бус, бүс нутгийн улс төр, соёлын харилцааг холбоход чухал үүрэг гүйцэтгэсэн болохыг харуулж байна. Ийнхүү XIII–XIV зууны үеийн харилцаа нь хоёр орны Бурханы шашны судалгаа, харьцуулалт, Ази тивийн шашны соёлын түүхийг ойлгоход чухал ач холбогдолтой бөгөөд өнөөдөр ч үнэ цэнээ алдаагүй хэвээр байна.

Ашигласан материал

Зава Дамдин Лувсандаян. “Их Монгол оронд Бурханы шашин дэлгэрсэн түүх. С.Гантөмөр орч. УБ.,1994.

ШУА-ийн Түүхийн хүрээлэн. Монгол Улсын түүх. УБ., 2003.

Ч. Далай, Их Монгол Улс. 1206–1260. УБ.,1994.

Д.Цэрэнсодном. Монголын Бурханы шашны уран зохиол. УБ.,1997.

- 송림(宋濂), 『원사 元史. (Сунрим. Юуан улсын түүх)
 Самгүг саги(三國史記) буюу Гурван улсын түүхийн тэмдэглэл
 김중서(金宗瑞) 외, 『고려사절요 高麗史節要.
 (Ким жунсо болон бусад. Кореа улсын түүхийн тайлбар)
 한정섭·김진필, 『몽골제국과 한몽관계사』, 불교정신문화원, 2005.
 (Хан жонсоб, Ким жингүөл. Монгол гүрэн ба Солонгос-Монголын харилцааны түүх)
 한정섭·김진필, 『중국불교문화사』, 불교정신문화원, 1999.
 (Хан жонсоб, Ким жингүөл. Хятадын бурхны шашин, соёлын түүх)
 최용범, 『하룻밤에 읽는 고려사』, 랜덤하우스, 2003.
 (Чуи юунбөм. Нэг хоногт унших Кореагийн түүх)
 산구서봉(山口瑞鳳), 이호근 역, 『티벳불교사』, 민족사, 1995.
 (Зохиогч: Сангүсөбун, И хугуны орчуулга. Төвөдийн бурхны шашны түүх)
 서윤길, 『고려밀교사상사연구』, 불광출판사, 1993.
 (Со юүнгил. Кореагийн тарний шашны үзэл баримтлал, түүхийн судалгаа)
 Buswell, R. E., & Lee, T. (2000). Korean Buddhism: Tradition and Transformation. Honolulu: University of Hawai'i Press.
 Buswell, R. E. (1991). The Zen Monastic Experience: Buddhist Practice in Contemporary Korea. Princeton: Princeton University Press.
<https://doi.org/10.1515/9780691216102>
 Shin, Y. (2014). Korean Buddhist Thought: Enlightenment and Practice. Seoul: Jimoondang.
 Kim, Hwansoo Ilmee. (2018). Empire of the Dharma: Korean and Japanese Buddhism, 1877–1912. Harvard University Asia Center.